



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/431

Булган сум

**Г Сайхан суманд орон нутгийн хамгаалалтын  
хээрийн дадлага, сургалт зохион байгуулах  
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.5.24, 66 дугаар зүйлийн 66.1.1, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3.3, 11.4.2, 11.8, 19 дүгээр зүйлийн 19.1.8, Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/110 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймагт орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний хээрийн дадлага, сургалт зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага, сургалтад шаардагдах 54,300,200 (тавин дөрвөн сая гурван зуун мянга хоёр зуу) төгрөгөөс 34,300,200 (гучин дөрвөн сая гурван зуун мянга хоёр зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын батлагдсан төсвөөс, 20,000,000 (хорин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэсгийн гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж, бэлтгэл ажлыг сайтар хангаж орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 30-наас 07 дугаар сарын 05-ны хооронд сахилга, баттай, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, нэгдсэн удирдлагаар хангаж, чанартай зохион байгуулж ажиллахыг Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлагууд, Сайхан сумын Засаг дарга, Цэргийн штаб (хурандаа Ч.Энхбаяр)-т тус тус даалгасугай

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагайд)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010567

Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар  
сарын...-ны өдрийн...-ны тоот  
захирамжийн нэгдүгээр хавсаргалт



Ажлын хэсгийн ахлагч –Цэргийн штабын дарга Хурандаа Ч.Энхбаяр

Гишүүд

- Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн захирагч  
Хурандаа Г.Эрдэнэбаяр
- Тагнуулын хэлтсийн дарга  
Хурандаа Б.Жавхлантөгс
- Хилийн цэргийн 0286 дугаар ангийн захирагч  
Хурандаа Л.Цогтжаргал
- Онцгой байдлын газрын дарга  
Хурандаа Ш.Баасандорж
- ШШГГ -ын дарга Хурандаа ДТөгсбаяр
- Цагдаагийн газрын дарга  
Дэд хурандаа Г.Ганбаяр
- Сайхан сумын Засаг дарга Д.Сансар-Очир
- Хэвлэл мэдээллийн албаны дарга Г.Алтанцэцэг
- Нийтлэг үйлчилгээний албаны дарга Х.Энхбаатар
- Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар

Нарийн бичгийн дарга:

Орон нутгийн хамгаалалтын бэлтгэл сургалтын  
офицер хошууч Б.Намнансүрэн

Аймгийн Засаг даргын 2024 оны  
06 дугаар сарын 10 өдрийн  
11/23 дугаар захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ХЭЭРИЙН ДАДЛАГА СУРГАЛТАД ШААРДАГДАХ  
САНХҮҮГИЙН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж		Тоо хэмжээ	Бүгд	Тайлбар
1	Байр хоол	Хүн	35000	120*7	29400000	120 хүн*7 хоног
2	Медаль	Хүн	15000	48	720000	Гар бөмбөгийн тэмцээнд
3	Өргөмжлөл	Хүн	50000	3	150000	Гар бөмбөгийн тэмцээнд
4	Аннос	ш	140000	2	280000	Сургалт
5	Буудлагын бай (наадаг бай)	ш	60000	10	600000	Буудлага
6	Булган аймгийн газрын зураг	ш	150000	2	300000	Маштаб 1см 400.000
7	Дэвтэр	Хүн	8000	120	960000	Сургалтад зориулж
8	Бал	Хүн	3000	120	360000	Сургалтад зориулж
9	Ус	Хүн	1500	120	180000	БХЯ, ЗХЖШ удирдлагуудад, сургагч багш нарт
10	Кофе, цай	ш	20000	5	100000	Сургалт
11	Нэг удаагийн аяга	ш	7500	20	150000	Сургалт
12	Буудлагын бай (модон бай)	ш	200000	1	200000	Буудлага
13	Түлшний мод	М <sup>3</sup>	500000	1	500000	Портер түлээ Сургалтын гал тогоонд хэрэглэх 4м
14	Хантааз	ш	50000	60	3000000	Сургалт
15	Дуулга	ш	120000	60	7200000	Сургалт
16	Өвдгөгч	ш	35000	60	2100000	Сургалт
17	Шаардагдах шатахуун /бензин/	Литр	2520	1000	2520000	Сургалтын бэлтгэл ажилд
18	Түлш	Литр	3680	500	1840000	Сургалтын бэлтгэл ажилд
19	Цахилгаан үүсгэвэр /мотор/	ш	4430000	1	4430000	Сургалтад /хээрийн/
Бүгд					54990000	